БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОБГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2020-113-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг:
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг:
Ахлах аудитор: П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

**Аудитын гэрчилгээ** ....3
Аудитын тайлан....5
2.1. Оршил ....5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага....5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт....5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ....6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ....6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ....6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга....7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ....8
2.13. Шилэн дансны мэдээлэл....9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ....9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл....9
Менежментийн захидал ....9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ....10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан....10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан....13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....21

**Аудитын гэрчилгээ**

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.01.06 № 30

танай ____________ -ны №____________ т

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА
Ш.БААСАНДОРЖ ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Онцгой байдлын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020059

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

## 2.1. Оршил

ОБГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга, дэд хурандаа Ш.Баасандорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ОБГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ОБГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 04-нээс 2020 оны 01 дүгээр сарын 05–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

ОБГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 21/33 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Байгууллагын эрхэм зорилго нь Цэргийн албыг хэвшүүлж, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, нийгмийн баталгааг дээшлүүлэх гамшгаас хамгаалах бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад оршино.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1.Орон нутагт гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэл, эмзэг байдлын ерөнхий үнэлгээ хийх .

2.Онцгой байдлын албаны боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэн сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төсвийн тухай хууль

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ОБГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Аclous программ хангамж ашигладаг байна.

ОБГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар ОБГ-ын 2019 онд бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд 17 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар материаллаг байдлын түвшинг сонгож, эрсдэлийн түвшинг “их, дунд, бага/” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1564354.4 мянган төгрөгөөс тооцон 31287.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 65820.4 мянган төгрөгөөр тооцсон нь батлагдсан төсвийг зардлын гүйцэтгэлтэй тулгахаар нийт зардлыг суурь үзүүлэлт болгохоор сонгон авч үзлээ.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

ОБГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос авлага 543.5 мянган төгрөгөөр, өглөг 4489.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | | 543.5 | 543.5 |
| **Нийт хөрөнгө** | 840300.1 | 840843.6 | 543.5 |
| Өр төлбөр | | 4489.7 | 4489.7 |

Авлага дансны үлдэгдэл мянган төгрөгийн үлдэгдлийг 543.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь шимтгэлийн мөнгө илүү шилжүүлсэн байна. Авлага дансны үлдэгдэлд өмнөх онд үүссэн 2177.6 мянган төгрөгийн авлагыг хувь хүмүүсээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 234567.7 мянган төгрөгөөр өссөн нь ОБЕГ-аас шилжүүлэн өгснийг орлогод авч ажиллажээ.

Бараа материалын дансны мянган төгрөгийн үлдэгдэл дээр 2019 онд төсвийн хөрөнгөөр 160503.7 мянган төгрөгийн материал худалдаж авсан байна. Энэ нь байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай материал бэлтгэсэн гэж үзэж байна.

Оны эцэст 395071.4 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 838039.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Бараа материалын дансанд 2019 оны хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн материал байхгүй, ОБЕГ-аас шилжүүлсэн материалыг бүрэн орлогод авч тайланд тусган ажиллажээ.

Үндсэн хөрөнгийн дансны 4589918.3 мянган төгрөгийн эхний үлдэгдэл дээр ОБЕГ-аас 94000.0 мянган төгрөгийн автомашиныг хандиваар шилжүүлэн өгснийг бүртгэл тайланд тусган ажиллажээ. Тухайн онд акталж хассан хөрөнгө байхгүй байна.

Урт хугацаат өр төлбөр үүсээгүй болно.

Өр төлбөр дансны өглөгийг энэ онд 4489.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж жилийн эцэст 4512.9 мянган төгрөгийг өглөгтэй тайлагнасан байна. Өглөг үүссэн шалтгаан нь түлш халаалтын санхүүжилт хүрэлцээгүй гэж үзэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй болно.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар ОБГ нь тайлант онд өөрийн орлогын төлөвлөлт хийгээгүй болно.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөрт зориулан 1743735.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1743735.4 мянган төгрөгийг урсгал зардалд батлагджээ.

Нийт зардлын 2769500.7 мянган төгрөгийг улсын төсвөөс 1743735.4, ОБЕГ-аас 1009389.5, ОНХС-аас 4346.0, ЗДНөөцөөс 12029.4 мянган төгрөгийн буюу нийт 2769500.7 мянган төгрөгийн санхүүжилт авч ажиллажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан үзэхэд цалингийн зардлаас 172.6 мянган төгрөгийг НДШ-ийн зардалд, түлш халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардалд 2980.1, цэвэр бохир усны зардалд 482.3 мянган төгрөгийг тус тус шилжүүлэн зарцуулсан байна. Төсвийн хэмнэлт байхгүй 100 хувийн зарцуулалтаар зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 4346.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 4346.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2769500.7 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт дансаар Засгийн газрын нөөц сан 12029.4, дээд шатны төсвийн захирагчаас 1009389.5, ОНХС-гаас 4346.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авч үндсэн үйл ажиллагааны хүрээнд зарцуулан ажилласан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 17 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 13 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 23018.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 11468.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 4630.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2825.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 4095.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 4630.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Бараа материалын тодруулга тайлангаар 4630000 төгрөгийн малын эхний үлдэгдэлд өөрчлөлт ороогүй, малын ашиг шимийн тооцоол хийгээгүй, өсөлт, бууралтыг үзүүлэлтээр тайлагнаагүй, “Лабрадор” үүлдрийн нохойг орлогод аваагүй нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйл, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх ”Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, НББ-ийн бодлогын бичиг баримтын 4.3 дахь “Бараа материалын бүртгэл” хэсгийн заалтуудыг тус тус бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Бараа материалыг бүрэн үнэн зөв орлогод аваагүй, авлага шинээр нэмэгдүүлсэн, сахилгын шийтгэл ногдуулсан ажилчдын цалингаас суутгалыг бүрэн тооцож аваагүй, малын өсөлт бууралт, хорогдлын үзүүлэлтийг материалын тайланд тайлагнаагүй зэрэг зөрчлийн авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### 2.13. Шилэн дансны мэдээлэл

ОБГ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд мэдээлж ажилласныг нийцлийн аудитаар нарийвчлан авч үзэх болно.

### 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлж зөвлөмж хүргүүлээгүй болно.

### 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ОБГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

ОБГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Бараа материал*

*1.1.* <u>*Илрүүлэлт:*</u> Байгууллагын хагас болон жилийн эцсийн хөрөнгийн тооллогын ажлын хэсгийн тайлан, хөрөнгө материалын үлдэгдэлтэй тулгахад хөрөнгийн тооллого хийсэн хөрөнгийн дүн нь санхүүгийн тайлангийн тодруулгад тусгасан хөрөнгө материалын дүнтэй ижил боловч ажлын хэсгийн тайлангийн утга ижил, цаашид ашиглах боломжгүй болсон бараа материал хөрөнгийг хасах, шаардлагатай материал хөрөнгийн талаарх саналыг тусгаж ажиллаагүй, мөн малын тоо ижил,

өсөлт, бууралтын үзүүлэлтийг тооцоогүй зэрэг зөрчлүүд илэрсэн нь хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнгүй, тооллогын үйл ажиллагааг явуулаагүй гэж дүгнэхэд хүргэж байна.

*1.2.* *Эрсдэл:*

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдох дотоод хяналт сулрах

*1.3.* *Өгсөн зөвлөмж:*

Төсвийн тухай хуулийн 6.4.8, НББ-ийн тухай хуулийн 20.2.5 дахь заалтуудыг мөрдөж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

*Зөвлөмжийн дагуу ажиллах*

*2. Зардал*

*2.1. Илрүүлэлт:* Томилолтын зардлын гүйцэтгэлийг түүвэрлэлтээр шалгахад өмнөх оны өглөгийн тайланд тусгаагүй 460.8 мянган төгрөгийг томилолтын зардалд олгосон зөрчил илэрлээ.

*2.2. Эрсдэл:* Санхүүгийн тайлан мэдээ буруу илэрхийлэгдэх, дотоод хяналт сулрах

*2.3. Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 6.4.8, НББ-ийн тухай хуулийн 20.2.5 дахь заалтуудыг мөрдөж ажиллах.

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар*: Зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийн дагуу ажиллах

*3. Зардал*

*2.1. Илрүүлэлт:* Байгууллагын батлагдсан төсөв гүйцэтгэлийг үзэхэд цалингийн зардлаас 172.6 мянган төгрөгийг НДШ-ийн зардалд, түлш халаалтын зардлаас 2980.1 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд, 482.3 мянган төгрөгийг цэвэр бохир усны зардалд тус тус шилжүүлэн зарцуулсан байна.

*2.2. Эрсдэл:* Санхүүгийн үйл ажиллагаа доголдох, өр авлага үүсэх

*2.3. Өгсөн зөвлөмж:*

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар*: Зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийн дагуу ажиллах

**Мэдэгдэл:**

Аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож 2020 оны 05 сарын 20-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг мэдэгдье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

ОБГ **СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 840,300,140.55 | 840,843,651.48 |
| 33 | АВЛАГА | 2,260,176.25 | 2,803,687.18 |

| | | | |
|---|---|---|---|
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 59,336.43 | 602,847.36 |
| **335** | **Бусад авлага** | 2,200,839.82 | 2,200,839.82 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 23,200.00 | 23,200.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,177,639.82 | 2,177,639.82 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 838,039,964.30 | 838,039,964.30 |
| **351** | **Түүхий эд материал** | 591,014,296.15 | 591,014,296.15 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 591,014,296.15 | 591,014,296.15 |
| **354** | **Хангамжийн материал** | 242,395,668.15 | 242,395,668.15 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 803,000.00 | 803,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 100,655,675.75 | 100,655,675.75 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 723,000.00 | 723,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 150,850.00 | 150,850.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 141,000.00 | 141,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 139,922,142.40 | 139,922,142.40 |
| 35600 | Мал амьтад | 4,630,000.00 | 4,630,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,104,904,904.21** | **2,954,493,036.80** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,104,904,904.21 | 2,954,493,036.80 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,807,561,504.21 | 2,657,149,636.80 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,726,039,086.27 | 1,726,039,086.27 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -264,536,371.80 | -351,945,136.03 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 2,069,059,669.48 | 2,163,059,669.48 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -753,112,027.28 | -909,794,376.98 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 391,809,553.88 | 391,809,553.88 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -361,935,886.38 | -362,204,941.40 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,473,367.09 | 36,473,367.09 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -36,235,887.05 | -36,287,585.49 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 66,148,218.28 | 66,148,218.28 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -66,148,218.28 | -66,148,218.28 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 297,343,400.00 | 297,343,400.00 |
| 39301 | Программ хангамж | 3,045,000.00 | 3,045,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -3,045,000.00 | -3,045,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 297,343,400.00 | 297,343,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,945,205,044.76** | **3,795,336,688.26** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **23,200.00** | **4,512,907.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 23,200.00 | 4,512,907.00 |
| **413** | **Өглөг** | 23,200.00 | 4,512,907.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 4,489,707.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 23,200.00 | 23,200.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 23,200.00 | 23,200.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,945,181,844.76** | **3,790,823,781.26** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,945,181,844.76 | 3,790,823,781.26 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,162,057,121.97 | 1,162,057,121.97 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,162,057,121.97 | 1,162,057,121.97 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,797,240,675.31 | 1,642,882,611.81 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,797,240,675.31 | 1,797,240,675.31 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -154,358,063.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 985,884,047.48 | 985,884,047.48 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,945,205,044.76** | **3,795,336,688.26** |

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ОБГ **СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,907,414,209.10** | **3,098,068,448.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **303,687,009.10** | **328,567,738.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 303,687,009.10 | 328,567,738.32 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 303,687,009.10 | 328,567,738.32 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 303,687,009.10 | 328,567,738.32 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,603,727,200.00** | **2,765,154,710.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,463,246,400.00 | 1,743,735,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,463,246,400.00 | 1,743,735,400.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 00.00 | 4,346,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 140,480,800.00 | 1,021,419,310.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,994,000.00 | 12,029,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,565,300.00 | 1,009,389,510.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,010,192,743.86** | **3,291,023,602.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,010,192,743.86** | **3,291,023,602.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,007,653,217.86 | 3,284,623,602.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,208,215,625.97 | 1,469,876,147.00 |
| 210101 | Үндсэн цалин | 838,586,225.97 | 956,861,293.00 |
| 210102 | Нэмэгдэл | 313,676,000.00 | 496,175,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 16,839,654.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,694,900.00 | 46,707,742.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,853,200.00 | 15,216,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,404,000.00 | 5,686,417.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,123,200.00 | 654,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 280,800.00 | 163,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,033,700.00 | 24,987,325.07 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 124,920,678.00 | 119,313,807.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,267,207.00 | 10,631,957.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 113,899,971.00 | 107,724,350.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 753,500.00 | 957,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 96,669,143.11 | 56,645,384.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,783,556.00 | 1,906,110.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 45,182,730.00 | 51,281,439.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,267,162.00 | 2,574,335.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 795,700.00 | 883,500.00 |
| **2105** | **Норматив зардал** | 45,896,363.50 | 71,359,793.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 178,200.00 | 892,803.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,256,700.00 | 34,009,197.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 28,461,463.50 | 36,457,793.20 |
